



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/562

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. ОХУ-ын Алтайн хязгаарын Белокуриха хотод зохион байгуулагдсан “Их Алтай” олон улсын арга хэмжээний зардалд 478 000 төгрөг, Тувагийн Бүгд Найрамдах Улсын Кызыл хотод болсон “Сибирийн хэлэлцээр” Масс бүс нутгийн холбооны хурлын арга хэмжээний зардалд 832 000 төгрөг, Швейцарийн Холбооны улсын Парлементийн дарга Марина Караббиог хүлээн авч хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон уулзалтын зардалд 2 332 000 төгрөг, Улсын баяр наадмын хаалтын үйл ажиллагаанд оролцсон ОХУ-ын Буриад улсын эстрадын дуучдын байрны зардалд 394 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 4 036 000 төгрөг /Дөрвөн сая гучин зургаан мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/562 дугаар захирамжийн хавсралт



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Зардлын төрөл зүйл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1. "Их Алтай" олон улсын арга хэмжээ					
1.	Калиграф бичилт	ш	1	50 000	50.0
2.	Бэлэг дурсгал /багц/	ш	10	42 800	428.0
	Дүн				478.0
2. "Сибирийн хэлэлцээр" масс бүс нутгийн холбооны хурлын арга хэмжээ					
1.	Монгол сувинер	ш	2	70 000	140.0
2.	Бэлэг дурсгал /багц/	ш	10	69 200	692.0
	Дүн				832.0
3. Швейцарын Холбооны улсын Парламентийн дарга Марина Караббиог хүлээн авч санал солилцох уулзалт арга хэмжээ					
1.	Зэс аяга	ш	1	30 000	30.0
2.	Хүрэм	ш	3	85 000	255.0
3.	Өргөмжлөл АЗ	ш	2	52 500	105.0
4.	Цагаан идээний багц бэлэг	уут	10	42 000	420.0
5.	Оройн зоог	тоо	20	25.400	508.0
6.	Хамтын ажиллагааны уулзалт хэлэлцүүлэг	тоо	30	21.97	659.0
7.	Сумдад ажиллах зардал	тоо	10	35 500	355.0
	Дүн				2 332.0
4. ОХУ-ын Буриад улсын эстрадын дуучдын байрны зардалд					
1.	Буудлын өрөө /1 хоног/	ш	2	70 000	140.0
2.	Хоолны зардал	тоо	10	25 400	254.0
	Дүн				394.0
	НИЙТ ДҮН				4 036.0